



2003 оны 27

24

Гадаадад суралцуулах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гантулга овогтой Чанцал, Элдэвсүрэн овогтой Ариунгэрэл, Шонхууз овогтой Энхтөр нарыг 2002-2003 оны хичээлийн жилээс АНУ-ын Де Врай Их сургуулийн Келлер удирдлагын сургуулийн магистрантурт төрийн захиргааны чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадад суралцуулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 247 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХАМГААГАХ
2003.07.27
СЭЙЛ, ШИНЖЛЭХ ТУШААЛ

САЙД - 2 *Э. Энхтөр*

А.ЦАНЖИД